



**СЭЛЭНГЭ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/57

Сант сум

**Шүлхий өвчнөөс сэргийлэх яаралтай
дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 59.1.12, 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3, 60 дугаар зүйлийн 60.2.8 дахь заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны А/87 тоот тушаал, аймгийн Засаг даргын 2023 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн “Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтыг зохион байгуулах тухай” А/214 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд мал амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтын ажлыг 2023 оны 4 дүгээр сарын 20 -ны өдрөөс 2023 оны 5 дугаар сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Дархлаажуулалтын арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай

Ажлын хэсгийн ахлагч :

Гишүүд:

А.Одхүү
(Засаг даргын Тамгын газрын дарга)
Д.Оюунэрдэнэ
(Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн)
Г.Анхбаяр
(Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч)
Л.Сэлэнгэсайхан
(Ивэн 1-р багийн Засаг дарга)
Б.Золбаяр
(Хушаат 2-р багийн Засаг дарга)
О.Лхагвасүрэн
(Сантбаянхайрхан МЭҮН-н захирал)
Ө.Ганбаатар
(Бошгын булаг ХХК-н захирал)

3. Ажлын хэсэгт ДААЛГАХ нь:

а) Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулах үйл ажиллагаанд аж ахуйн нэгж байгууллага, малчин, мал бүхий өрхийн 2022 оны жилийн эцсийн мал тооллогод хамрагдсан үхэр, гахайг бүрэн хамруулах.

б) Дархлаажуулалтын явцад мал амьтны шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулах.

Боловсруулсан: *Т. Анхберг*
Хянасан: *Ч. Агваар*
Хувь: *2*
Огноо: *2013.04.20*

в) Дархлаажуулах ажлаас малаа хоцроосон, зайлс хийсэн аж ахуйн нэгж байгууллага, иргэд, хариуцлагагүй хандсан албан тушаалтанд хуулийн дагуу арга хэмжээ авч хариуцлага тооцох.

г) Дархлаажуулалтын товлосон хугацаанд мал, амьтныг бэлэн байлгаж бэхлэх, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдүүлж, малын эмчийн аюулгүй байдлыг бүрэн хангах

д) Энэ арга хэмжээний зорилго ач холбогдол хор хохирлын талаар ухуулга сурталчилгаа зохион байгуулах.

е) Дархлаажуулалтын ажилд зарцуулагдах шатахууны зардалыг малын тоо толгойн албан татварын орлогоос санхүүжүүлэхийг санхүү албаны дарга (Г.Ууганцэцэг)-д үүрэг болгосугай.

4. Дархлаажуулалтын ажлыг товлот хугацаанд чанартай хийж, гүйцэтгэл холбогдох мэдээ тайланг гарган санхүүжилтийн материалыг бүрдүүлэн сумын Засаг даргаар батлуулж аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (А.Одхүү)-д үүрэг болгосугай.

A red official stamp with a central emblem and vertical text on the sides. A handwritten signature in black ink is written over the stamp.

С.ШИЖИРБААТАР